ДУНДГОВЬ АЙМАГ
**ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 11 сарын 08 өдөр    Дугаар А/105    Хажуу шинэ ус

Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж , түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1 заалт, Малын эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйл 17.2, 17.2.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Морьт багийн нутаг “Цагаан даравгай” нутаглаж байгаа малчны суурьт малын гоц халдварт Бог малын мялзан өвчин оношлогдож хорио цээрийн дэглэм цуцалж хязгаарлалтын дэглэм шилжүүлсэн 14 хоногийн хугацаанд Мялзан өвчнөөр мал нэмж өвчлөөгүй тул хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2.Хязгаарлалтын дэглэмийг цуцалсантай холбогдуулан халдваргүйтгэл хийж отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг, “Угтаал чандмань” мал эмнэлэг үйлчилгээний нэгжид даалгасугай.

ЗАСАГ ДАРГА    Ө. МӨНХ-АМГАЛАН

482201105